



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах нүүрсний үнийг хянах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалын 3, 4 дүгээр зүйл, “Багануур” ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/541, 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/799 дүгээр албан бичгүүдийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй нүүрсний үнийн тооцоог 1 ккал илчлэг тутамд 16.84 (арван зургаан төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөг буюу нэг тонн тутамд 56,574.0 (Тавин зургаан мянга таван зуун далан дөрөв) төгрөгөөс ихгүй байхаар хянасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах нүүрсний үнийг хянах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 167 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

Л.ДАШМЯГМАРЖАВ

А.АЗБАЯР

Д.ЦОГОО

Б.ЭНХЖАРГАЛ